



**Хэвлэлийн мэдээ**  
Пүрэв гариг, 2015 оны 11-р сарын 19.

**Холбогдох утас:**  
+976 9999-7104

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим Монгол Улсад  
АНУ-аас суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд  
Женифер Зимдал Галтад хүндэтгэл үзүүлэв**

Улаанбаатар хот, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) Монгол Улсад Америкийн Нэгдсэн Улсаас суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Женифер Зимдал Галтад хүндэтгэл үзүүлэн 2015 оны 11-р сарын 19-нд Вагнер Ази Автомотив Форд, Рейнж Роверийн шоу танхимд хүлээн авалт зохион байгууллаа. Хүлээн авалтад гадаад дотоодын 100 гаруй бизнесийн төлөөлөл оролцов.

Хүндэтгэлийн хүлээн авалтад Элчин сайд Галт хэлсэн үгэндээ “АНУ-ын ЭСЯ нь Монголд чөлөөт зах зээл, бизнесийн төлөө тууштай үйл ажиллагаа явуулдаг АмЧамтай хамтарч буйдаа бахархаж байна” гэв.

“АмЧам нь Элчин сайд Галтыг Монголд ирсэнд туйлын баяртай байгаа бөгөөд Монголд бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хувийн хэвшлийг хөгжүүлэх, хоёр орны худалдааны харилцааг хөхүүлэн дэмжих талаар үр дүнтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байна” гэж АмЧамын ТУЗ-ийн дэд дарга Г. Магнай онцлон тэмдэглэв.

Энэхүү хүлээн авалтыг АмЧамын гишүүн болох МСМ групп болон Вагнер Ази Автомотив компани ивээн тэтгэсэн юм.

**АмЧамын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улсын хооронд бизнесийн түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

АмЧам Монгол нь сар бүрийн уулзалтад зохион байгуулдаг ба үүнд Монголын болон олон улсын нөлөө бүхий бизнесийн төлөөлөгчид оролцож хувийн хэвшлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргагчдыг урьж санал бодлоо хуваалцдаг юм.